

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц”  
ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)  
Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)  
Аудитор Н.Энхчимэг  
Цахим хаяг: [Enkhchimeg@audit.gov.mn](mailto:Enkhchimeg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.13 № 152  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭМАНДАЛ “ХӨГЖЛИЙН ДЭД  
БҮТЭЦ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ДАРГА Г.БАТТУЛГА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Архангай аймаг дахь “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Санхүүгийн тайланд 9,129.7 мянган төгрөгийн халаалтын авлага, 4,834.8 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй орхигдуулсан,
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын өр 10,103.8 мянган төгрөг, ХАОАТ-ын 4,147.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан,
3. Албан хаагчдын цалинг 2,027.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.5-, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохилдсон байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Удирдлагын болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,013,615.92	406,513.66
1.1.2	Дансны авлага	-	16,034,517.16
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	5,979,413.23	4,147,491.75
1.1.6	Бараа материал	20,854,428.60	42,147,118.39
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>31,847,457.75</b>	<b>62,735,640.96</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	259,578,222.00	184,366,453.82
1.2.2	Биет бус хөрөнгө	4,206,000.00	1,575,437.64
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>263,784,222.00</b>	<b>185,941,891.46</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>295,631,679.75</b>	<b>248,677,532.42</b>
2.1.1.1	Дансны өглөг	16,333,762.50	96,321,561.48
2.1.1.3	Татварын өр	9,185,272.93	24,211,113.89
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>25,519,035.43</b>	<b>120,532,675.37</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>25,519,035.43</b>	<b>120,532,675.37</b>
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	68,844,000.00	68,844,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	201,268,644.32	59,300,857.05
<b>2.3.6</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>270,112,644.32</b>	<b>128,144,857.05</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>295,631,679.75</b>	<b>248,677,532.42</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр. дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого(цэвэр)</b>	<b>538,013,649.67</b>	<b>607,008,038.47</b>
2	Борлуулалтын өртөг	286,586,852.18	114,406,865.56
<b>3</b>	<b>Нийт ашиг(алдагдал)</b>	<b>251,426,797.49</b>	<b>492,601,172.91</b>
7	Эрхийн шимтгэлийн орлого	4,044,074.82	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	195,880,592.74	-
10	Ерөнхий удирдлагын зардал	-	634,568,960.18
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>59,590,279.57</b>	<b>-141,967,787.27</b>
19	Орлогын татварын зардал	5,959,027.96	-
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>53,631,251.61</b>	<b>-141,967,787.27</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>53,631,251.61</b>	<b>-141,967,787.27</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>53,631,251.61</b>	<b>-141,967,787.27</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эздийн өмчийн	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	201,268,644.32	201,268,644.32
2	Өмчид гарсан өөрчлөлт	68,844,000.00	-	68,844,000.00
<b>3</b>	<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>68,844,000.00</b>	<b>201,268,644.32</b>	<b>270,112,644.32</b>
<b>4</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>68,844,000.00</b>	<b>201,268,644.32</b>	<b>270,112,644.32</b>
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-141,967,787.27	-141,967,787.27
<b>6</b>	<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>68,844,000.00</b>	<b>59,300,857.05</b>	<b>128,144,857.05</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөр. дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	595,859,091.49	661,095,710.69
	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	591,815,016.67	650,999,618.69
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	4,044,074.82	-
	Бусад мөнгөн орлого	-	10,096,092.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	526,737,702.40	665,702,812.95
	Ажиллагчдад төлсөн	138,041,158.82	247,617,345.53
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	25,292,565.58	74,610,813.91
	Бараа материал худалдан авахад төлсөн	15,189,950.00	9,380,550.00
	Ашиглалтын зардалд төлсөн	59,175,156.43	26,621,476.87
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	235,487,656.00	103,083,020.38
	Татварын байгууллагад төлсөн	53,047,415.57	59,135,051.16
	Бусад мөнгөн зарлага	503,800.00	145,254,555.10
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>69,121,389.09</b>	<b>-4,607,102.26</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	127,127,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	124,507,000.00	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,620,000.00	-
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-127,127,000.00</b>	<b>-</b>
<b>2.3</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-58,005,610.91</b>	<b>-4,607,102.26</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>63,019,226.83</b>	<b>5,013,615.92</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,013,615.92</b>	<b>406,513.66</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 207,506.7 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 118,454.3 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 5,178.3 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Чөлөөтэй албан хаагчдын цалинг тооцож олгохдоо нэмэгдлийг үндсэн цалингаас тооцон 2,027,904.18 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** *Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.*

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд НӨАТ-ын өглөг 24,211.1 мянган төгрөг, нүүрсний үнэ 82,824.6 мянган төгрөг, нүүрсний тээврийн хөлс 7,043.3 мянган, засварын материал 1,608.9 мянган нийт 115,687.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** *Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.*

5.1.2 Тайлант хугацаанд орлого 132,754.9 мянган төгрөгөөр дутуу 607,008.0 мянган төгрөг төвлөрч гүйцэтгэлээр 748,975.7 мянган төгрөгийг зарцуулан 141,967.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг" 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10-т "Захирал дор дурдсан бүрэн эрхтэй" Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** *Тухайн жилийн бизнес төлөвлөгөө болон орлого, зардал, ашиг, алдагдлыг бодиттой тооцоо судалгаанд тулгуурлан эдийн засгийн үндэслэлтэй боловсруулж батлуулах албан шаардлагыг хүргүүллээ.*

5.1.3 Цалинг давтан тооцоолол хийж тулган шатгахад чөлөөтэй албан хаагчдын цалинг тооцож олгохдоо цалингийн суутгалыг буруу тооцож 738,440.18 төгрөгийг дутуу олгосон байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрүүтэй тусгаж илэрхийлсэн	1	156,440.4	1	156,440.4	1	156,440.4		
Буруу тусгаж илэрхийлсэн	1	13,277.2	1	13,277.2	1	13,277.2		
Буруу тусгаж илэрхийлсэн	1	14,948.6	1	14,948.6	1	14,948.6		
Буруу тусгаж илэрхийлсэн	1	990.7	1	990.7	1	990.7		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>185,656.9</b>	<b>4</b>	<b>185,656.9</b>	<b>4</b>	<b>185,656.9</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	115,687.9			1	115,687.9
Бизнес төлөвлөөг үндэслэлтэй төлөвлөөгүй	1	00.0			1	00.0
Цалин илүү олгосон	1	2,027.9	1	2,027.9		
Цалин дутуу олгосон	1	738.4			1	738.4
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>118,454.3</b>	<b>1</b>	<b>2,027.9</b>	<b>3</b>	<b>116,426.4</b>

